



6 24  
Ректорын 2011 оны...-р сарын... өдрийн  
А/Б тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

## ШУТИС-ИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ, МСҮТ-ИЙН БАГШИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 ШУТИС-ийн мэргэжлийн сургалттай бүрэлдэхүүн сургууль, Политехник коллеж, МСҮТ /цаашид сургууль гэнэ/ -н багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох, Мэргэжлийн боловсрол сургалтын газрын даргын "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох үлгэрчилсэн журам"-ыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Сургуулийн багшийн албан тушаал нь ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн зэрэглэлтэй байна.

1.3 Багшийн албан тушаалын зэрэглэл нь тухайн багшийн цагийн хөлс, жилд гүйцэтгэх танхимын ба танхимын бус сургалтын багц цагийг тогтоох үндэслэл болно.

1.4 Багш нь тухайн жилийн ажлын үр дүнгийн талаар өөрийн үнэлгээний тайлан бичиж, нотлох баримтын хамт албан тушаалыг шинэчлэн тогтоолгох саналаа сургуулийн захиргаанд гаргана.

1.5 Сургуулийн захиргаа нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ дүгнэлт өгч багшийн албан тушаалын зэрэглэл тогтоох тухай материалыг ШУТИС-ийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын албанд ирүүлнэ.

1.6 Багшийн зэрэглэл тогтоох тухай шалгалтыг жилд нэг удаа Ректорын тушаалаар байгуулагдсан комисс авч сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлж Ректорын тушаалаар баталгаажуулна.

### ХОЁР. Багшийн албан тушаалын зэрэглэлд тавих нийтлэг шаардлага

2.1 Ерөнхий соёл ба харилцааны чадвар


2.1.1 Багш нь Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартыг мөрддөг, суртачилдаг байх

2.1.2 Багшид тавигдах үндсэн шаардлагыг биелүүлдэг, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх

2.1.3 Багшийн ёс зүйг сахидаг, боловсролын харилцаанд оролцогсдыг дэмжин тэднийг хүндэтгэж эрхийг нь дээдэлдэг байх

2.1.4 Суралцагчдын хөгжил, төлөвшлийн тасралтгүй өсөлт, сургалтын ажлын үр дүнг оновчтой, бодитой тодорхойлон тухайн орчин нөхцөл нөөцөд тулгуурлан тодорхой үр дүнд хүргэх санаачлагатай байх

2.1.5 Хамт олны дунд эвсэг, нөхөрсөг зан байдлыг эрхэмлэн багаар ажиллах чадвартай байх



Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн  
... тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

## **2.2 Бүтээлч чадвар**

2.2.1 Багш өөрөө тасралтгүй хөгжиж, шинэ санаа санаачлага дэвшүүлэн ажил үүргийг шуурхай гүйцэтгэж, үйл ажиллагаандаа бодиттой хандах ажил хэрэгч чанарыг эрхэмлэсэн байх

2.2.2 Сургалтанд шинэ арга технологийг нэвтрүүлж суралцагчдын хэрэгцээнд тохируулан боловсоруулж, практикт хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх

2.2.3 Сургуулийн зорилго, зорилтод нийцүүлэн сургалтын лаборатори, кабинет тоноглох, тохижуулах, төсөлт ажилд оролцох, бусад хэлбэрээр сургууль хөгжүүлэх ажилд хувь нэмрээ оруулдаг байх

## **2.3 Мэргэжлийн чадвар**

2.3.1 Багш нь бакалавр түүнээс дээш зэрэгтэй буюу үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байх

2.3.2 Багш нь мэргэжлийн боловсролын сургах зүйн сургалтад хамрагдаж багшлах эрхийн үнэмлэх авсан байх

2.3.3 Судалгааны үндсэн дээр сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, заах арга, сургалтын арга зүйг боловсронгуй болгодог сургалтын технологич байх

2.3.4 Мэдээллийн технологийн дэвшилтэд арга хэрэгсэлд тулгуурласан сургалт зохион байгуулдаг байх

2.3.5 Сургалтын үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийдэг сургалтын чанарыг сайжруулах арга замыг тодорхойлдог байх

## **2.4 Судалгаа шинжилгээний чадвар**

2.4.1 Судалгааны арга зүй эзэмшсэн байх

2.4.2 Мэдээллийн хэрэгцээг тодорхойлох, мэдээллийг олж цуглуулах түүндээ дүн шинжилгээ хийх, ашиглах, түгээх чадвар эзэмшсэн байх

2.4.3 Өөрийн эзэмшсэн мэргэжлийн болон боловсрол судлалын чиглэлээр судалгааны ажил, төсөл боловсруулж ажилладаг байх

2.4.4 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийн ажлыг цогцолбороор явуулах арга барилд суралцсан байх


## **2.5 Бусад**

2.5.1 Нийгмийн түншлэлийг өргөжүүлэхэд идэвхи санаачлагатай оролцдог байх

2.5.2 Гадаад хэлний мэдлэгээ байнга дээшлүүлж түүнийгээ сургалтандаа үр дүнтэй ашигладаг, мэргэжлийн англи хэлтэй байх

**Гурав. Багшийн албан тушаалын зэрэглэлийн нийтлэг шалгуур үзүүлэлт**

### **3.1 Ахлах багш:**




Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн  
... тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

- а) Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан ба үйлдвэрлэлийн ажлын дадлага туршлагатай, мэргэжлийн тэргүүлэхээс доошгүй зэрэгтэй, багшлах эрхтэй байх
- б) Мэргэжлийн ур чадвар, заах арга зүйгээр бусдыг үлгэрлэн манлайлж, зөвлөн туслаж түгээн дэлгэрүүлдэг туршлагатай байх
- в) Салбар нэгжийн хүрээнд сургалт, судалгаа шинжилгээний ажлыг чанартай гүйцэтгэдэг болохоо тодорхой үр дүнгээр харуулсан харуулж байгаа
- г) Улс, бүсийн ажил мэргэжлийн уралдаан тэмцээн, олимпиадад багш өөрөө болон шавь нь шагналт байранд шалгарсан байх /сүүлийн 3-5 жилийн амжилтыг тооцох /
- д) Бүтээлийн үзэсгэлэн гаргах
- е) Сургах зүйн судалгаа туршилтын ажлын аргачлал боловсруулах, дүн шинжилгээ хийх, үр дүнд нь тулгуурлан төсөл хөтөлбөр бичих
- ё) Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйг эзэмшиж, сургалт зохион байгуулах, түгээн дэлгэрүүлэх
- ж) Мэргэжлээрээ шинэ техник технологи, стандарт норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтдаа ашиглах, кабинет, лаборатори, дадлагын газрыг тоноглох, тохижуулахад идэвхи санаачлагатай оролцох
- з) Багш нарыг шинэ мэдээллээр хангах, багш, дадлагажигч багшийг дагалдуулан буюу удирдах замаар зөвлөн туслах, ажлын арга барилд сургадаг байх
- и) Багш суралцагчдад зориулсан зөвлөмж, гарын авлага боловсруулах, ном сурах бичиг бичих ажлын хэсэгт ажиллах, зөвлөгөө өгөх
- й) Багш заадаг хичээлийнхээ 50-аас доошгүй хувьд нь мэдээллийн технологийг ашиглаж тодорхой үр дүнд хүрсэн байх
- к) Суралцагчдад нийгэм болон хөдөлмөрийн соёл, хамт олны дунд ажиллахад шаардагдах хандлага зан төлөвийн чадамжуудыг эзэмшүүлэх

**3.2 Багш:**

- а) Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 2-аас доошгүй жил ажилласан буюу үйлдвэрлэлийн ажлын зохих дадлага туршлагатай, багшлах эрхтэй байх ба мэргэжлийн заах аргач зэрэгтэй байх
- б) Суралцагчдын сурах- сургах үйл явцыг оновчтой төлөвлөж, харьцуулан жишиж, сургалтын чанарыг сайжруулах арга замыг тодорхойлдог байх
- в) Үндсэн нэгжийн хүрээнд сургалт, судалгаа шинжилгээний ажлыг чанартай гүйцэтгэдэг болохоо тодорхой үр дүнгээр харуулсан харуулж байгаа
- г) Улс, бүсийн ажил мэргэжлийн уралдаан тэмцээн, олимпиадад багш өөрөө болон шавь нь шагналт байранд шалгарсан байх /сүүлийн 3-5 жилийн амжилтыг тооцох /



- д) Мэргэжлээрээ шинэ техник технологи, стандарт норматив хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтандаа ашиглах, кабинет, лаборатори, дадлагын газрыг тоноглох, тохижуулахад оролцох
- е) чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйг эзэмшсэн байх
- ё) Сургалтын шинэ дэвшилтэт аргуудыг хэрэглэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн сургалт явуулах, хичээл зааж туршлага солилцдог байх
- ж) Багш суралцагчдад зориулсан зөвлөмж, гарын авлага боловсруулах ном сурах бичиг бичих ажлын хэсэгт ажиллах
- з) Багш заадаг хичээлийнхээ 30-аас доошгүй хувьд нь мэдээллийн технологийг ашиглаж тодорхой үр дүнд хүрсэн байх
- и) Суралцагчдад нийгэм болон хөдөлмөрийн соёл, хамт олны дунд ажиллахад шаардагдах хандлага зан төлөвийн чадамжуудыг эзэмшүүлэх

### 3.3 Дадлагажигч багш:

- а) Бакалавраас доошгүй зэрэгтэй байх буюу үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, багшлах эрхтэй байх
- б) Судалгааны арга зүй эзэмшиж, тодорхой чиглэлээр судалгаа хийх бэлтгэлтэй байх
- в) Хичээлийг стандартын шаардлага хангасан хөтөлбөрөөр чанартай заадаг байх
- г) Мэргэжлээрээ шинэ техник технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтандаа ашиглах
- д) Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйг эзэмших
- е) Ахлах багшийн зөвлөмжийн дагуу сургалтын шинэ дэвшилтэт асуудлыг хэрэглэн нээлттэй хичээл зааж туршлага судлах, солилцох
- ё) Багш заадаг хичээлийнхээ 25-аас доошгүй хувьд нь мэдээллийн технологийг ашиглаж тодорхой үр дүнд хүрсэн байх
- ж) Суралцагчдад нийгэм болон хөдөлмөрийн соёл, хамт олны дунд ажиллахад шаардагдах хандлага зан төлөвийн чадамжуудыг эзэмшүүлэх
4. Дэд профессор, профессор цолны болзол хангасан мэргэжлийн сургалттай бүрэлдэхүүн сургууль, Политехник коллеж, МСҮТ-ийн багш нарт "ШУТИС-ийн дэд профессор, профессор цол олгох журам"-ын дагуу цол олгож болно.